

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

..... оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь биеийн тамир, спортын салбарын тогтолцоо, үйл ажиллагаа, биеийн тамирын ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлж, биеийн тамир, спортыг хүн амын хэрэгцээ, сонирхол болон спортын холбоод, бусад салбар, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж

2.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол уг олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."биеийн тамир, спорт" гэж хүн эрүүл мэндээ бэхжүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, тамирчин амжилт гаргах зорилгоор хичээллэх бүхий л хэлбэрийн үйл ажиллагааг;

3.1.2."идэвхтэй хөдөлгөөн" гэж хүний булчингийн үйл ажиллагааны тусламжтайгаар зорилготой, тогтмол, тодорхой хугацаанд хүч зарцуулан хийж байгаа хөдөлгөөнийг;

3.1.3."биеийн тамир" гэж хүн эрүүл мэндээ бэхжүүлэх, бие бялдраа хөгжүүлэх зорилгоор хийж байгаа идэвхтэй хөдөлгөөнийг;

3.1.4."спорт" гэж биеийн тамирын хөгжлийн үр дүнд амжилтын төлөө тэмцээнд бэлтгэн оролцож, шударгаар өрсөлдөж байгаа үйл ажиллагааг;

3.1.5."мэргэжлийн спорт" гэж тухайн спортын төрлөөр өндөр зэрэглэлийн тамирчдын өрсөлдөөнийг ашиг олох зорилгоор зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааг;

3.1.6."чийрэгжүүлэлт" гэж хувь хүний бие бялдрын онцлог, тусгай хэрэгцээнд тохирсон идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэндийг бэхжүүлэх сэргээн засах үйл ажиллагааг;

3.1.7.“бие бялдрын боловсрол” гэж биеийн тамир, спортоор хичээллэхэд хувь хүний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг;

3.1.8.“биеийн тамирын ажил, үйлчилгээ” гэж хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох, бие бялдрын боловсрол олгох, чийрэгжүүлэх, тэднийг биеийн тамираар хичээллэх нөхцлийг бүрдүүлэх бүхий л үйл ажиллагааг,

3.1.9.“спортын ажил, үйлчилгээ” гэж тамирчдад сургалт-дасгалжуулалт явуулж бэлтгэх, спортын тэмцээн, наадам зохион байгуулах, оролцуулах, барилга байгууламж, тоног төхөөрөмжөөр хангах бүхий л үйл ажиллагааг;

3.1.10.“спортын тэмцээн” гэж спортын тодорхой төрлөөр тогтоогдсон дүрмийн дагуу зохион байгуулагдаж, тамирчдын шударга өрсөлдөөнийг хангах арга хэмжээг;

3.1.11.“спортын наадам” гэж спортын тодорхой төрлүүдийн тэмцээнийг нэгдсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа спорт, соёл урлагийн цогц арга хэмжээг;

3.1.12.“тамирчин” гэж спортын тодорхой төрлөөр тогтмол хичээллэж, биеийн тамир, спортын тэмцээн, наадамд оролцдог этгээдийг;

3.1.13.“биеийн тамир, спортын ажилтан” гэж биеийн тамир, спортын мэргэжил эзэмшин биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж байгаа ажилтаныг;

3.1.14.“дасгалжуулагч” гэж биеийн тамир, спортын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, тамирчин бэлтгэх, тэднийг тэмцээнд оролцох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх мэргэшлийн зөвшөөрөл, зэрэг бүхий ажилтаныг;

3.1.15.“биеийн тамирын арга зүйч” гэж хүн амд бие бялдрын боловсрол олгох, иргэдийг биеийн тамир, спортоор зөв хичээллэх арга барилыг зааж сургах ажил, үйлчилгээ эрхлэх мэргэшлийн зэрэг, зөвшөөрөл бүхий ажилтаныг;

3.1.16.“биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага” гэж биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажил, үйлчилгээ үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.17.“спортын холбоо” гэж биеийн тамир, спортын чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж, үндэсний хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагыг;

3.1.18.“биеийн тамир, спортын клуб” гэж тухайн спортын холбоонд гишүүнчлэлтэй, хүн амд бие бялдрын боловсрол олгох, чийрэгжүүлэх, сургалт-дасгалжуулалт явуулах, тамирчдыг бэлтгэж, тэмцээн, наадамд оролцуулах ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.19.“үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэстний онцлог шинжийг агуулсан спортыг.

4 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчим

4.1.Биеийн тамир, спортын байгууллага удирдах үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

4.1.1.хүн ам бие бялдрын боловсролоо дээшлүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх үйл явц нийтэд хүртээмжтэй, сайн дурын үндсэн дээр байх;

4.1.2.иргэдэд бие бялдрын боловсрол олгох үйл явц шинжлэх ухааны үндэслэлтэй, тасралтгүй, залгамж шинжтэй байх;

4.1.3.биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ нь төрийн бүх шатны байгууллага, спортын төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний харилцан

үр ашигтай хамтын ажиллагаан дээр тулгуурласан нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих;

4.1.4.биеийн тамир, спортын аливаа үйл ажиллагаа нь хүмүүнлэг, шударга өрсөлдөөн, хүйсийн эрх тэгш байдал эрхэмлэсэн, допинг, хээл хахуул, хожлын наймаа, ялгаварлан гадуурхал, хүчирхийлэл, үндэстэн дамнасан гэмт хэрэг, архи, тамхи, мансууруулах аливаа хорт бодисоос ангид байлгах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛААР ТӨРИЙН УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Улсын Их Хурал нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

5.1.2.биеийн тамир, спортын асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

5.1.3.олон улс, тив, дэлхий, үндэсний хэмжээний наадмыг эх орондоо зохион байгуулахтай холбогдуулан спортын барилга байгууламж, дэд бүцийг хөгжүүлэх урт хугацааны баримт бичиг батлах;

5.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.2.хүн амын нас, хүйс, хэрэгцээ сонирхолд тулгуурласан спортын төрлийг хөгжүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спортын зорилтот хөтөлбөр батлах;

6.1.3.монголын баг тамирчид олимп, дэлхий, тивийн түвшинд спортын өндөр амжилт гаргах, эх орондоо тив, дэлхийн чанартай тэмцээн, наадмыг хүлээн авч зохион байгуулах нөхцлийг үе шаттайгаар бүрдүүлэх;

6.1.4.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль хэрэгжүүлэхэд спортын төрийн бус байгууллага болон бусад холбогдох байгууллагын оролцоог хангах, Олимпын наадамд бэлтгэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуулан байгуулах;

6.1.5.Монгол Улсад олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээн, наадам болон үндэсний хэмжээний спортын наадам зохион байгуулах шийдвэр гаргах;

6.1.6.олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадмыг эх орондоо зохион байгуулах, үндэсний хэмжээний наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх, эрх олгох журам батлах;

6.1.7.үндэсний спортыг өсвөр, залуу үеийнхэнд өвлүүлэн дэлгэрүүлэх, хамгаалах, олон улсад сурталчилахад дэмжлэг үзүүлэх;

6.1.8.үндэсний шигшээ багийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сургалт дасгалжуулалт явуулах орчин бүрдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

6.1.9.олимп, тивийн наадам, дэлхийн аваргын болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнах, урамшуулал олгох журам батлах;

6.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

7.1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар орон нутгийн бодлого тодорхойлох, хөтөлбөр батлах;

7.1.2.орон нутгийн биеийн тамир, спортын хөгжилд шаардагдах төсөв батлах, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

7.1.3.орон нутгийн хэмжээнд сум, аймаг, дүүрэг, хотын аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах, үндэсний тэмцээн, наадамд баг тамирчидаа бэлтгэх, оролцуулах;

7.1.4.үндэсний хэмжээний болон олон улсын спортын тэмцээн, наадмыг орон нутагтаа зохион байгуулах саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх;

7.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог дэмжих, тэднийг урамшуулах;

7.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7.2.Бүх шатны Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1.харьяалах нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах;

7.2.2.харьяалах нутаг дэвсгэртээ иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэв маяг төлөвшүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцох;

7.2.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;

7.2.4.аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын газар, суманд биеийн тамир, спортын орон тооны арга зүйч ажиллуулах;

7.2.5.харьяалах нутаг дэвсгэртээ спортын 8-аас доошгүй төрлөөр өсвөр үе, 6-аас доошгүй төрлөөр залуучууд, насанд хүрэгчдийн шигшээ баг байгуулж, дасгалжуулагч ажиллуулах, биеийн тамир, спортын заал, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хувцас, шаардагдах санхүүжилтээр хангах;

7.2.6.орон нутгийн хэмжээнд сум, аймаг, дүүрэг, хотын аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах, үндэсний тэмцээн, наадамд баг тамирчидаа бэлтгэн оролцуулах, зардлыг санхүүжүүлэх;

7.2.7.биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохируулан тоноглох, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах;

7.2.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2.аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

8.1.3.биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний норматив, улсын төсвөөс санхүүжүүлэх ажил, үйлчилгээг тогтоох;

8.1.4.хүн амд бие бялдрын боловсрол төлөвшүүлэхэд төр, төрийн бус болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог хангах;

8.1.5. хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг тогтоож, хөгжүүлэх арга хэмжээ авах;

8.1.6.биеийн тамир, спортын ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх, дасгалжуулагч, арга зүйчдийг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, хугацааг сунгах, цуцлах журам батлан мөрдүүлэх;

8.1.7.биеийн тамир, спортын магадлан итгэмжлэл хэрэгжих нөхцөл бүрдүүлэх;

8.1.8.хөгжлийн бэрхшээлтэй тамирчины тэмцээнд орох ангиллыг Олон улсын паралимпийн холбооны шаардлагад нийцүүлэн тогтоох үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл томилон ажиллуулах, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

8.1.9.улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох журам батлах;

8.1.10.биеийн тамир, спортын төрийн зарим чиг үүргийг спортын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхэд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

8.1.11.энэ хуулийн 6.1.6, 8.1.9-д заасан тэмцээн, наадмыг зохион байгуулах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

8.1.12.үндэсний шигшээ баг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмыг батлах;

8.1.13.тамирчин, шүүгчид цол олгох спортын төрөл, шалгуур үзүүлэлтийг тогтоох;

8.1.14.биеийн тамир, спортын үйл ажиллагааны мэдээллийн үндэсний цахим сан бүрдүүлэх, ажиллуулах журмыг батлан мөрдүүлэх;

8.1.15.спортын эрдэм шинжилгээ, анагаах ухааны ололтыг нэвтрүүлж, судалгаа шинжилгээний хүрээг өргөжүүлэх, спортын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

8.1.16.биеийн тамир, спортын ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх, дасгалжуулагч, арга зүйчид мэргэшлийн зэрэг, зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах журам батлан мөрдүүлэх;

8.1.17.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл.Төрийн захиргааны бусад төв байгууллагын үүрэг

9.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1.1.бие бялдрын боловсрол нь боловсролын агуулгын нэг хэсэг бөгөөд биеийн тамирын хичээлээр олгож, суралцагчдыг бие бялдрын өв тэгш хөгжилтэй иргэн болгон төлөвшүүлэх;

9.1.2.бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөнд биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тусгах;

9.1.3.бүх шатны боловсролын сургалтын байгууллага суралцагчдыг хичээлээс гадуурх сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадамд оролцох бололцоогоор хангах, зохион байгуулах;

9.1.4.аймаг, нийслэлийн хэмжээнд дотуур байртай орон нутгийн өмчит спортын дунд сургуулийг байгуулж ажиллуулах;

9.1.5.өмчийн бүх хэлбэрийн боловсролын байгууллага суралцагчдийн сургуулийн орчинд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангаж, үндэсний стандартад нийцсэн биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

9.1.6.суралцагч бүрийн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорил авч, үнэлгээг тогтоох, бие бялдрыг хөгжүүлэх арга хэмжээ авах;

9.1.7.биеийн тамирын багш спортын тодорхой төрлөөр сургалт-дасгалжуулалт явуулах, түүнд олгох нэмэгдэл хөлс, урамшуулал олгох журмыг боловсрол, санхүү, төсвийн болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, мөрдүүлэх;

9.1.8.бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь биеийн тамир, спортын заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийг суралцагсдад төлбөртэйгээр үйлчлэхийг хориглох.

9.2.Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн нийтийн эзэмшлийн газрын орчинд спортын барилга байгууламжийг нэг хүнд ногдох талбайн хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон стандарт, норм, нормативыг боловсруулж мөрдүүлнэ.

9.3.Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь нийтийн эзэмшлийн замын төлөвлөлтөд явган хүний зам, дугуйн замын стандартыг боловсруулна.

9.4.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.4.1.хүн амын хөдөлгөөний хомсдлыг бууруулах асуудлыг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг хэсэг болгон зохион байгуулах;

9.4.2.спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.

9.5.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.5.1.спортын гэмтлийн улмаас эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулах сэргээн засах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалаар санхүүжүүлэх тусламж, үйлчилгээнд хамруулах;

9.5.2.эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний товлोलт хугацаанд бүрэн хамрагдсанаас хойш 3 жил дараалан эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагч магадлан итгэмжлэгдсэн **биеийн тамир, спортын клубын** биеийн тамирын урамшуулалт үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хамрагдах журам батлах;

9.6.Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага дараах үүрэг хүлээнэ:

9.6.1.бие бүрэлдэхүүнд бие бялдрын боловсрол олгох, биеийн тамир, спортын тэмцээн, наадам зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

9.6.2.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийн тусгай норм, норматив тогтоох, тусгай сургалтын хөтөлбөр батлан мөрдүүлэх;

9.6.3.зэвсэгт хүчний болон төрийн зарим тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын бие бүрэлдэхүүн болон ажилтныг цэргийн алба хаах, мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон спортоор хичээллэх нөхцөл бололцоогоор хангах;

9.6.4.энэ хуулийн 9.6-д заасан байгууллага дэргэдээ бие бүрэлдэхүүн, ажилтаны бие бялдрын хөгжлийг хангах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчин бэлтгэх биеийн тамир, спортын хороо ажиллуулах;

9.6.5.хууль тогтоомжид заасны дагуу спортын шүүгч, дасгалжуулагч болон мэргэжлийн бусад ажилтаны мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

10 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан байгууллагын үүрэг

10.1.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан байгууллага нь биеийн тамир, спортыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, спортын төрийн бус байгууллага, бусад салбарын хүрээнд хөгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих болон биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэх байгууллагыг магадлан итгэмжлэх, дасгалжуулагч, арга зүйчдэд мэргэшлийн зэрэг, зөвшөөрөл олгох, эрдэм шинжилгээ, спортын анагаах ухаан, спортын эмнэлэг хөгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

10.2.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан байгууллага дараах үүрэг хүлээнэ:

10.2.1.энэ хуулийн 13.2-т заасан спортын төрлөөр спортын холбоодын дэргэд ажиллаж байгаа үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих;

10.2.2.үндэсний хэмжээнд зохион байгуулагдах спортын наадмын төрөл, хугацааг тогтоох, зохион байгуулах эрх олгох, санхүүжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;

10.2.3.олон улсын чанартай тэмцээнд Монгол Улсыг төлөөлж оролцох тамирчдыг бэлтгэх зорилгоор спортын холбоод үндэсний шигшээ баг байгуулж, багийн бүрэлдэхүүнийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж, олон нийтэд зарлах;

10.2.4.биеийн тамир, спортын байгууллагын зорилго, үүрэгт харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд иргэн, байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэхээс татгалзах, таслан зогсоох;

10.2.5.биеийн тамир, спортын үйл ажиллагаатай холбогдон гарах үндэсний стандарт, дүрэм, зааврыг олон улсын спортын байгууллагын дүрэм, шаардлагад нийцүүлэн боловсруулж, шийдвэрлүүлэх;

10.2.6.хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох, биеийн тамираар хичээллэж, идэвхтэй хөдөлгөөнийг эрүүл аж төрөх хэв маягийн нэг болгон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах;

10.2.7.спортын эрдэм шинжилгээ, анагаах ухааны ололтыг нэвтрүүлж, судалгаа шинжилгээний хүрээг өргөжүүлэх, спортын эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн ам болон тамирчдад үзүүлэх, биеийн тамир, спортын бэртэл гэмтэл, спортын өвчин эмгэг болон хэт ачааллын улмаас тамирчин, дасгалжуулагч, ахмад тамирчдын эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг арилгах сэргээн засах тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх;

10.2.8.биеийн тамир, спортын магадлан итгэмжлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;

10.2.9.тамирчин, дасгалжуулагчийн ёс зүйн дүрмийг боловсруулж, мөрдүүлэх;

10.2.10.биеийн тамир, спортын мэдээллийн цахим сангийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх;

10.2.11.тамирчин, шүүгчид цол олгох спортын төрөл, шалгуур үзүүлэлтийг тогтоох;

10.2.12.Монгол Улсад зохиогдож байгаа тэмцээн, наадамд оролцож байгаа тамирчдад Олон улсын допингийн эсрэг агентлагийн дүрэмд заасан ажил, үйлчилгээг жил бүр зохион байгуулж улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10.2.13.иргэн, тамирчин бие бялдраа хөгжүүлэх, сэргээх зорилгоор хэрэглэж байгаа биологийн идэвхт бодисын хэрэглээ, импорт, худалдаа, үйлдвэрлэлд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хяналт тавих, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бэлэглэх, худалдах, сурталчилахыг хориглох арга хэмжээг авах;

10.2.14.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ТОГТОЛЦОО

11 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний төрөл

11.1.Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ нь биеийн тамир, үндэсний спорт, ашгийн бус сонирхогчдын спорт, ашгийн төлөөх мэргэжлийн спорт гэсэн төрөлтэй байна.

11.2.Хүн амын бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, бие бялдрын хөгжлийн түвшинг тогтоох, идэвхтэй хөдөлгөөнийг хүн амын эрүүл аж төрөх хэв маягийн нэг болгон хөгжүүлэх зорилгоор биеийн тамир, спортын байгууллага дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулах ажил, үйлчилгээг бүх нийтийн спорт буюу биеийн тамирт хамруулна.

11.3.Спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, хувь хүний спортын авьяасыг илрүүлэх, амжилтыг тогтоох, өндөр зэрэглэлийн тамирчдыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх зорилгоор спортоор хичээллэгчдийн дунд спортын байгууллагын удирдлага, спортын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хяналтан дор зохион байгуулагдаж байгаа спортын ажил, үйлчилгээг сонирхогчдын спортод хамруулна.

11.4.Баяр наадмын тухай хуулиар зохицуулагдаагүй бусад үндэсний спортын тэмцээн, наадмыг энэ хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл.Биеийн тамир, спортын салбарын тогтолцоо

12.1.Биеийн тамир, спортын салбарын тогтолцоо нь биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ хариуцсан төрийн байгууллага, эрдэм, шинжилгээ, судалгаа, сургалт, спортын анагаах ухаан, үндэсний шигшээ баг болон спортын холбоод, клуб, бусад салбар байгууллага дах биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгжээс бүрдэнэ.

12.2.Биеийн тамир, спортын төрийн удирдлагын тогтолцоо нь биеийн тамирын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, суманд биеийн тамир, спортын орон тооны арга зүйчээс бүрдэнэ.

12.3.Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын байгууллагад таваас доошгүй жил ажилласан мэргэжлийн ажилтнаас сонгон шалгаруулж, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн орон нутгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

12.4.Дүүргийн биеийн тамир, спортын газрын даргыг нийслэлийн биеийн тамир, спортын хорооны даргатай зөвшилцөн дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

12.5.Сумын биеийн тамир, спортын арга зүйчийг тухайн орон нутгийн биеийн тамир, спортын газрын даргатай зөвшилцөн сумын Засаг дарга томилж, чөлөөлнө.

13 дугаар зүйл. Үндэсний шигшээ баг

13.1.Үндэсний шигшээ баг нь өсвөр үеийн, залуучуудын, насанд хүрэгчдийн гэсэн төрөлтэй байна.

13.2.Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, дэлхий, тивийн тэмцээн, наадамд оролцох насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг энэ хуулийн 8.1.12-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж, тухайн спортын холбоодын дэргэд ажиллуулна.

13.3.Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааны дүрмийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага батална.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасны дагуу сонгогдсон спортын холбоотой биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага гэрээ байгуулах бөгөөд үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

13.5.Олон улсын олимпийн болон паралимпийн хорооны ивээл доор явагдах спортын наадамд Монгол Улсыг төлөөлж оролцох үндэсний шигшээ багт үзүүлэх төрийн дэмжлэгийн хэмжээг өмнөх жилийнхээс бууруулахгүй байна.

13.6.Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн шигшээ багийг спортын тодорхой төрлөөр тухайн спортын холбоодтой хамтран байгуулна.

13.7.Олон улсын оюутны спортын холбооны ивээл доор явагдах оюутны универсиад наадамд Монгол Улсыг төлөөлж оролцох оюутны шигшээ багийг энэ хуулийн 14.2.1 болон 14.2.2 талууд сонгон шалгаруулж бүрдүүлнэ.

13.8.Энэ хуулийн 13.7-д заасан оюутны шигшээ багт наадмын бэлтгэл хангах, тэмцээнд оролцоход төрөөс зохих дэмжлэг үзүүлнэ.

14 дүгээр зүйл. Спортын холбооны зохион байгуулалт, эрх үүрэг

14.1.Спортын холбооны Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулагдаагүй дараах харилцааг энэ хуулиар зохицуулна.

14.2.Спортын холбоог дараах байдлаар ангилна:

14.2.1.тухайн спортын төрлийн эдийн бус хөрөнгө болох нэр, ажил, үйлчилгээний тэмдэг, ажил, үйлчилгээ, үзэл баримтлал, дүрмийг эзэмшиж байгаа холбоог спортын төрлийг эзэмшигч холбоо;

14.2.2.спортын төрлийг нэгтгэн өөрийн зорилгод хэрэглэж байгаа төрийн бус байгууллагыг спортын төрлийг хэрэглэгч холбоо;

14.2.3. тухайн спортын төрлийн хөгжилд мэргэжлийн чиг үүргийн хувьд үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагыг спортын төрлийн хөгжилд туслагч холбоо.

14.3. Спортын төрийн бус байгууллагад үзүүлэх төрийн дэмжлэгийг **энэ хуулийн 8.1.10-д заасан шаардлагыг хангасан** нэг холбоонд үзүүлж, олон улсын гэрээ, конвенцийн дагуу хамтран ажиллана.

14.4. Тухайн спортын төрлийн холбоо нь олон улсын холбооны бүтэц, зохион байгуулалтад нийцсэн нэгдсэн холбоо болон салбар холбоо, клубтэй байх ба гишүүнчлэлийн татвартай байна.

14.5. Спортын холбооны эдийн бус хөрөнгө нь тэдгээрийн өмч бөгөөд зөвхөн тэдний зөвшөөрөлтэйгээр ашиглана.

14.6. Спортын холбоо нь тухайн спортын төрлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, бие даасан байдлыг бэхжүүлэх, төр, төрийн бус байгууллагын нэгдмэл үйл ажиллагааг хангуулах үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна.

14.7. Спортын холбоо, салбар холбооны дүрэм, хамтран ажиллах журмыг спортын холбооны Удирдах зөвлөл хэлэлцэн батална.

14.8. Спортын холбоо доор дурдсан эрх эдэлнэ:

14.8.1. спортын тухайн төрлөөр олон улс, тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах;

14.8.2. бүсийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулах тэмцээний календарчилсан төлөвлөгөө, дүрэм, заавар, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

14.8.3. дасгалжуулагч, спортын шүүгчийг аттестатчилах, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих; 14.8.4. олон улсын спортын холбооны дүрэм, харти, конвенц, хууль тогтоомжийн хүрээнд салбар холбоо байгуулах, тухайн спортын төрлөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг биеийн тамир, спортын клубт олгох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаа, үр дүнд хяналт тавих, хариуцлага тооцож ажиллах;

14.8.5. тухайн спортын төрлөөр шигшээ баг бүрдүүлэх, бэлтгэх, энэ хуулийн 13.2-т заасны дагуу сонгон шалгарсан спортын холбоод үндэсний шигшээ баг бүрдүүлэх;

14.8.6. энэ хуулийн 18.1, 18.2-т заасан болзлыг хангасан тамирдад спортын цол, зэрэг олгох;

14.8.7. олон улсын спортын холбооны дүрэм, харти, конвенцийн хэм хэмжээний заалтаар бүх шатны тэмцээнд оролцох эрхээ хязгаарлуулсан тамирчныг спортын тэмцээн, наадамд оролцуулахгүй байхад хяналт тавих, мэдээлэх;

14.8.8. допингийн эсрэг дүрэм, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тамирчин, дасгалжуулагч болон спортын бусад ажилтанд спортын тэмцээн, наадамд оролцох эрхийг нь хасах хүртэл хариуцлага ногдуулах, холбогдох байгууллагад болон олон нийтэд мэдээлэх;

14.8.9. аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулан харилцан ашигтай ажиллах;

14.8.10. тухайн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс дэмжлэг авах;

14.8.11. хуульд заасан бусад эрх.

14.9. Спортын холбоо доор дурдсан үүрэг хүлээнэ:

14.9.1. олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, тайлан мэдээг цаг тухайд нь гаргах;

14.9.2. спортын тухайн төрөл, тамирчдыг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр болон бүс, улсын, олон улсын спортын арга хэмжээнд

оролцох төлөвлөгөөтэй ажиллах, биеийн тамир, спортын байгууллагын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулах;

14.9.3.салбар холбоо, клубээр дамжуулан хүн амын дунд спортын тэмцээнийг зохион байгуулах;

14.9.4.холбооны шигшээ багийг бүрдүүлэх бэлтгэх, тамирчдыг тэмцээн, наадамд оролцуулах;

14.9.5.тухайн спортын төрлөөр хүний нөөц бэлтгэх, ажилтаны мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх;

14.9.6.тамирчдын сургалт-дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохион байгуулах, тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

14.9.7.холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан тэмцээн, наадам, тамирчдын амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлээр мэдээллийн цахим сантай байх;

14.9.8.спорт дах допинг, ялгаварлал, хүчирхийллийн аливаа хэлбэрийг гаргуулахгүй байх, гарсан зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх;

14.9.9.тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад хэрэглүүлэх, сурталчилахтай тэмцэх;

14.9.10.Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээний дагуу гүйцэтгэж болно.

14.9.11.Энэ хуулийн 14.9.10-д заасан ажил, үйлчилгээг зориулалтын дагуу зарцуулж, үр дүн, санхүүжилтийн тайланг олон нийтэд ил бод байлгана.

14.9.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл.Биеийн тамир, спортын клубын зохион байгуулалт, эрх, үүрэг

15.1. Биеийн тамир, спортын клуб нь хүн амд бие бялдрын боловсрол олгох, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, авьяаслаг тамирчдыг илрүүлэх, бэлтгэх, спортын сургалт-дасгалжуулалт явуулж өндөр зэрэглэлийн тамирчинг тэмцээн, наадамд оролцуулах ажил, үйлчилгээ эрхэлнэ.

15.2.Клуб нь **төрийн бус байгууллагын** болон аж ахуйн нэгжийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд тухайн спортын холбоонд бүртгэлтэй байна.

15.3.Иргэн, аж ахуйн нэгж болон дээд боловсролын сургалтын байгууллага биеийн тамир, спортын клубтэй байж болно.

15.4.Биеийн тамир, спортын клуб доор дурдсан эрх эдэлнэ:

15.4.1.хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагааны дүрэм, дотоод журмаа батлан мөрдүүлэх;

15.4.2.тамирчин, дасгалжуулагч, шүүгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах;

15.4.3.тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчдээс спортын клубын дотоод журам, спортын үйл ажиллагаа эрхлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

15.4.4.хууль тогтоомжид заасан бусад эрх.

15.5.Биеийн тамир, спортын клуб доор дурдсан үүрэгтэй:

15.5.1.хүн амын дунд биеийн тамир, спортыг сурталчилах, бие бялдрын боловсролыг төлөвшүүлэх, авьяаслаг тамирчдыг илрүүлж сургалт-дасгалжуулалтаар хангах, тамирчдын залгамж халаа, өндөр зэрэглэлийн тамирчин бэлтгэх;

15.5.2.сургалт-дасгалжуулалтыг эмчийн хяналтын доор зохион байгуулах, тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн эрүүл мэнд, бие бялдар, үйл ажиллагаанд хяналт тавих;

15.5.3.биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн зохион байгуулах;

15.5.4.сургалт-дасгалжуулалтад болон спортын заал, талбай, сургалт-дасгалжуулалтын стандартын шаардлагыг хангаж ажиллах;

15.5.5.спортын холбоонд тогтоосон хугацаанд мэдээ тайлан гаргаж өгөх;

15.5.6.иргэд, тамирчдын бие бялдар, эрүүл мэндэд хохирол учруулах эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлдвэрлэх, тамирчдад зааж сургах, хэрэглүүлэх, сурталчилахыг хориглох;

15.5.7.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага дах биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ

16.1.Аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр биеийн тамир, спортын дараах ажил, үйлчилгээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ:

16.1.1.ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан ажилтны спортоор хичээллэх орчин бүрдүүлэх;

16.1.2.байгууллагын нийт төсвийн 1-ээс багагүй хувийг ажилтан биеийн тамир, спортоор хичээллэхэд зарцуулах;

16.1.3.байгууллагадаа биеийн тамир, спортын клуб байгуулан ажиллуулах, биеийн тамир, спортын асуудал хариуцсан ажилтантай байх;

16.1.4.спортын тэмцээн жил бүр зохион байгуулах;

16.1.5.ажилтны бие бялдрын хөгжлийн түвшинг тогтоох, хөгжүүлэх арга хэмжээ авах.

16.2.Амралт, сувиллын газар, хүүхдийн зуслан нь спортын заал, ил талбай, тоног төхөөрөмжөөр тоноглож, спорт, чийрэгжүүлэлтийн ажлыг холбогдох ажилтны оролцоотойгоор зохион байгуулна.

16.3.Аж ахуйн нэгж байгууллага мэргэжлийн спортын тэмцээн зохион байгуулахдаа тухайн спортын төрлийг эзэмшигч холбоотой франчайзын гэрээ байгуулан ажиллаж, хариуцлага хүлээнэ.

17 дугаар зүйл.Тамирчны эрх, үүрэг

17.1.Тамирчин доор дурдсан эрх эдэлнэ:

17.1.1.спортын төрлөө чөлөөтэй сонгох, спортоор хичээллэх;

17.1.2.спортын тэмцээн, наадамд оролцох;

17.1.3.энэ хуулийн 18.1,18.2- т заасан болзол хангасан бол спортын цол, зэрэг авах;

17.1.4.харьяалагддаг спортын холбоо, клубээс гэрээний дагуу спортын өөр холбоо, клубт шилжих;

17.1.5.тэмцээнд бэлтгэх, оролцох хугацаанд үндсэн ажил, сургуулиас холбогдох журмын дагуу чөлөөлөгдөх;

17.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

17.2. Тамирчин доор дурдсан үүрэг хүлээнэ:

17.2.1.спортын тэмцээн, наадмын үед болон бэлтгэл, дасгалжуулалтын явцад аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэх;

17.2.2.шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, допинг хэрэглэхгүй байх, допингийн шалгалтад заавал хамрагдаж байх;

17.2.3.эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдаж байх;

17.2.4.биеийн тамир, спортоор хичээллэгчдийн эрүүл мэндэд хохирол учруулах хориотой мэх, арга барил хэрэглэхгүй байх, эм, бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, худалдан авахаас татгалзах, бэлэглэх, зааж сургах, худалдахгүй, сурталчилахгүй байх;

17.2.5.тамирчны ёс зүйн дүрмийг мөрдөх;

17.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

18 дугаар зүйл.Спортын цол зэрэг

18.1.Энэ хуулийн 8.1.13-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тамирчинд Олон улсын мастер, Монгол Улсын спортын мастер, шүүгчид Улсын шүүгч цолыг спортын холбоод олгоно.

18.2.Спортын зэрэг олгох болзол, шалгуурыг тухайн спортын холбоо тогтоон олгоно.

18.3.Спортын цол, зэргийн болзлыг хангасан тамирчин, шүүгчид тухайн нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага мөнгөн урамшуулал олгож болно.

18.4.Монгол Улсын спортын мастер, олон улсын мастер цол хүртсэн тамирчинд харьяа байгууллага нь цолны нэмэгдэл хөлсийг сар бүр өөрсдөө тогтоон олгоно.

18.5.Энэ хуулийн 10.2.10, 14.9.7-д заасан мэдээллийн цахим санд бүртгэлгүй тамирчин, шүүгчид спортын цол олгохыг хориглоно.

19 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт

19.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд биеийн тамир, спортын ажилтаныг төгсөлтийн дараа мэргэшүүлэх, давтан сургах асуудал хариуцсан орон тооны нэгж ажиллуулах бөгөөд нэгжийн дүрэм, ажиллах журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20 дугаар зүйл.Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэл, дэмжлэг

20.1.Магадлан итгэмжлэл нь биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ эрхэлж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллагын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны түвшин, үр дүн, сургалт-дасгалжуулалтын чанар, орчны стандартад хөндлөнгийн мэргэжлийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа мөн.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан байгууллагын магадлан итгэмжлэл сайн дурын үндсэн дээр хийгдэнэ.

20.3.Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэлийн төрөл, шатлал, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, магадлан итгэмжлэл явуулах шинжээчийн ажиллах журам, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

20.4.Магадлан итгэмжлэлийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон хараат бус шинжээчийн баг хэрэгжүүлнэ.

20.5.Энэ хуулийн 9.5.2-т заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ажил, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн хэмжээг биеийн тамир, спортын болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САНХҮҮЖИЛТ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

21 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын санхүүжилт

21.1.Биеийн тамир, спортын зардал улсын болон орон нутгийн төсөвт бие даасан зардлын зүйл байна.

21.2.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхдээ бие даасан, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангаж, хандивын болон төсвийн бус санхүүжилтийг дэмжинэ.

21.3.Энэ хуулийн 6.1.2, 6.1.5-6.1.6, 6.1.8-6.1.9, 8.1.4-8.1.9, 8.1.11, 8.1.13, 10.2.10, 10.2.13, 11.4-д заасан үйл ажиллагааг улсын төсвөөс, 7.1.2-7.1.3, 7.2.1-7.2.7, 11.4-д заасан үйл ажиллагааг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

22 дугаар зүйл.Биеийн тамир, спортын барилга байгууламж

22.1.Спортын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа үндэсний стандартыг, стандарт байхгүй тохиолдолд олон улсын спортын холбоодын дүрэмд заасан техникийн нөхцөл, шаардлагыг баримтална.

22.2.Спортын барилга байгууламжийн ашиглалтын зардлын тооцоо нь энэ хуулийн 22.1-т заасан зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг байна.

22.3.Биеийн тамир, спортын барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагад нийцсэн дэд бүтэц, хэрэгцээт тохируулгаар тоноглогдсон байна.

22.4.Барилгын тухай хууль болон энэ хуулийн 22.1-т заасан шаардлага хангаагүй, спортын барилга байгууламжгүй орон сууцны хороолол барихыг хориглоно.

22.5.Төрийн болон орон нутгийн өмчид байгаа спортын барилга байгууламжийн зориулалт, ашиглалтын чиглэлийг өөрчлөхийг хориглоно.

22.6.Бүх шатны боловсролын байгууллагын барилгыг биеийн тамир, спортын байгууламжгүй барих, ашиглалтад хүлээн авахыг хориглоно.

22.7. Төрийн өмчлөлд байгаа биеийн тамир, спортын байгууламжийг адил байгууламж барихгүйгээр буулгахыг хориглоно.

22.8.Хувийн хөрөнгө оруулалтаар барьж, магадлан итгэмжлэгдсэн спортын барилга, байгууламжийн үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж болно.

22.9.Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар баригдсан, улсын төсвийн санхүүжилттэй болон энэ хуулийн 22.8-д заагдсан биеийн тамир, спортын байгууллагад хүүхэд, оюутан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үнэ тариф тогтоох, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн, наадам зохион байгуулахад хөнгөлөлт үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

23 дугаар зүйл.Биеийн тамир, спортыг хөгжлийг дэмжих сан

23.1.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан байгууллагын санаачлагаар “Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих сан” байгуулж болно. Сан нь энэ хууль болон Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

23.1.1.Сан нь Удирдах зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага, спортын ивээн тэтгэгч, хандивлагч, хөрөнгө оруулагч, спортын холбоодын ижил тэнцүү төлөөлөл ажиллана.

23.1.2.Сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагыг олон нийтэд ил тод байлгана.

23.1.3. Сан нь аж ахуйн тооцон дээр ажиллах ба дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

23.1.3.1.сангийн эрхлэх спорт лото, спортын бооцоот тааварын үйл ажиллагаанаас олсон орлого;

23.1.3.2.мэргэжлийн спортын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох хураамжийн төлбөр;

23.1.3.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, тамирчины хандив, тусламж;

23.1.3.4.олон улсын байгууллага, хандивлагч улс орон, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, тусламж;

23.1.3.5.өөрийн үйл ажиллагааны орлого;

23.1.3.6.бусад эх үүсвэр.

23.1.4.Сангийн хөрөнгөөс дараах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ:

23.1.4.1.биеийн тамир, спортод дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх;

23.1.4.2.шаардлагатай спортын төрлүүдээр гадаадын өндөр зэрэглэлийн дасгалжуулагч, мэргэжилтнийг богино хугацаагаар ажиллуулах, сургалт явуулах;

23.1.4.3.олимп, паралимпийн наадамд оролцох эрх авах спортын төрлийн тоог нэмэгдүүлэх, тэмцээнд оролцоход дэмжих;

23.1.4.4.зодог тайлсан өндөр зэрэглэлийн тамирчид мэргэжил эзэмших, мэргэшүүлэх;

23.1.4.5.олимп, паралимпийн наадамд оролцсон болон өндөр зэрэглэлийн тамирчдын гадаадад эмчлүүлэх зардал;

23.1.4.6.биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих төсөл хэрэгжүүлэх;

23.1.4.7.хуулиар хориглоогүй сангийн дүрмээр зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа;

23.1.4.8.сангийн ажлын албаны зардал.

23.1.5.Сангийн ажлын албаны зардал нь энэ хуулийн 23.1.4.1-23.1.4.7-д заасан хөрөнгийн 5-аас хэтрэхгүй хувь байна.

23.1.6.Сангийн үйл ажиллагаанд биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

23.1.7.Сан нь үйл ажиллагаагаа биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлагнаж, хөндлөнгийн аудит хийлгэнэ.

24 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын ивээн тэтгэлэг, хандив

24.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, спортын холбоо, спортын клуб биеийн тамир, спортын тэмцээн, наадмын арга хэмжээг ивээн тэтгэж, хандив өгч болно.

24.2.Энэ хуулийн 24.1 дэх хэсэг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйл, Тамхины хяналтын тухай хуулийн 8.1.4 дэх заалтад зааснаар тамхи, архи, согтууруулах ундаа үйлдвэрлэгч, импортлогч хуулийн этгээдэд хамаарахгүй.

24.3.Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн байгууллагын маркетингийн бус зориулалтаар тухайн спортын хөгжилд зориулан үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийг спортын хандивт, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн спортын төрлийг ашиглан өөрийн байгууллагын маркетингийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн санхүүгийн дэмжлэгийг спортын ивээн тэтгэлэгт хамааруулна.

24.4.Биеийн тамир, спортын тэмцээн, наадамд хандив, ивээн тэтгэлэг үзүүлсэн байгууллагын сурталчилгаанд тамирчид, дасгалжуулагчид гэрээний дагуу оролцож болно.

24.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас спортын хөгжилд зориулсан хандив, биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний зардал, спортын заал, талбай, түүний дэд бүтцийг барихад оруулсан хөрөнгө оруулалт, энэ хуулийн **23.1.3.3-т** оруулсан хандивт ногдох албан татварыг хүн амын орлогын, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдэлнэ.

24.6.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын спортын хөгжилд үзүүлсэн хандив, тусламж, хөрөнгө оруулалтыг Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих сангийн мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулсанаар 24.5-д заасан татварын хөнгөлөлт эдлэх эрхтэй.

25 дугаар зүйл.Биеийн тамир, спортын ажилтны нийгмийн баталгаа

25.1.Биеийн тамир, спортын ажилтны цалингийн тусгай сүлжээний жишгийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний төрөл, онцлог, мэргэшлийн зэргийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

25.2.Тамирчин доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

25.2.1.тамирчин олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлбэл Засгийн газраас мөнгөн шагнал, урамшуулал болон бусад байгууллагын урамшуулал авах;

25.2.2.энэ хуулийн 13.2-т заасан үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагч цалин хөлс авах;

25.2.3.үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагч 2 жилд 1 удаа иж бүрэн хувцас, спортын хэрэгслээр хангагдах;

25.2.4.эрүүл мэндийн даатгалд даатгуулсан, спортын гэмтэлтэй тамирчинд үзүүлэх өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэх.

25.3.Биеийн тамир, спортын ажилтан доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

25.3.1.хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлог, мэргэшлийн зэрэг, гүйцэтгэсэн хөдөлмөрийнхөө чанар, хэмжээнд тохирсон цалин хөлс, илүү цагийн нэмэгдэл хөлс, нөхөн олговор, тусламж, шагнал, урамшуулал авах;

25.3.2.орон нутгийн онцлогийг харгалзан нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагаас нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

25.3.3.орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж байгаа биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагч 4 жилд нэг удаа мэргэжил дээшлүүлэх сургалтад улсын зардлаар хамрагдах;

25.3.4.биеийн тамир, спортын бэртэл гэмтэл, спортын өвчин эмгэг болон хэт ачааллын улмаас тамирчин, дасгалжуулагч, ахмад тамирчдын эрүүл мэндэд үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулах сэргээн засах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу үзүүлэх.

25.4.Төрийн өмчийн биеийн тамир, спортын байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажиллаж, тэтгэвэр тогтоолгосон биеийн тамир, спортын ажилтанд 24 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас тооцуулан ажиллаж байгаа байгууллагаасаа авах эрхтэй. Нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.

25.5.Энэ хуулийн 25.4-т заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусгана.

26 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

26.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.

26.2.Аж ахуй нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага энэхүү хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

26.3.Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлдэг төрийн бус байгууллага Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж болно.

26.4.Спортын холбоо өөрийн зохион байгуулж байгаа ажил, үйлчилгээнд дотоодын хяналт тавина.

26.5.Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэд, тамирчид бие бялдраа хөгжүүлэх, сэргээх зорилгоор хэрэглэж байгаа биологийн идэвхт бодисын эрүүл мэндийн дүгнэлтийг төрөл тус бүрээр импортлогчид олгож, худалдаа, үйлчилгээнд хяналт тавина.

27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол доор дурдсан захиргааны шийтгэлийг хууль тогтоомжийн дагуу шат шатны шүүгч болон тусгайлан эрх олгосон хяналтын улсын байцаагч ногдуулна:

27.1.1.Энэ хуулийн 14.8.6, 18.5-д заасныг зөрчсөн ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хороос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, спортын цолыг хүчингүй болгоно.

27.1.2.энэ хуулийн 14.9.7, 22.9-д заасныг зөрчсөн ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

27.1.3.энэ хуулийн 14.9.11-д заасныг зөрчсөн удирдах ажилтаныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас жар дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учирсан хохирлыг

удирдах зөвлөлөөр нөхөн төлүүлж, удирдах багийг шинээр байгуулах шаардлага тавих, хэрвээ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг 2 жил хүртэлх хугацаагаар цуцлах хүртэл арга хэмжээ авах;

27.1.4.энэ хуулийн 14.9.8, 17.2.2, 17.2.4-д заасныг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, Олон улсын допингийн эсрэг агентлагийн дүрмийн дагуу тэмцээн, наадамд оролцох эрхийг хасах;

27.1.5.энэ хуулийн 10.2.13, 14.8.7, 14.8.8, 14.9.9, 15.5.6, 26.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

27.1.6.энэ хуулийн 22.1, 22.4, 22.5, 22.6, 22.7-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар хүчингүй болгоно.

27.2.Энэ хуулийн 27.1.1, 27.1.2, 27.1.4, 27.1.5-д заасныг хууль сахиулах байгууллагад мэдээлсэн иргэнд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгож, нууцыг хадгална.

27.3.Спортын албан ёсны бэлтгэл, сургуулилт, тэмцээний үед иргэний эрүүл мэндэд учруулсан гэм хорыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд арилгана.

28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

28.1.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

28.2.Энэ хуулийн 9.1.5, 9.5.2 дах заалтыг 2020 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ